

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал

Аймгийн ЗДТГазар Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг бүртгэл хяналтанд авч 13 сум, нэг тосгон, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 хэрэгжүүлэгч агентлагт хүргүүлэн дараахь ажлуудыг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцож байна.

1. 2004 оноос хойш шинэчилж, баяжуулаагүй байсан аймгийн веб сайтыг энэ онд бүрэн шинэчилж, түүнд доорхи мэдээллүүдийг байршууллаа.

а/ сум, агентлагийн танилцуулга, тэдгээрийн эрхэм зорилго үйл ажиллагааны стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл

б/ удирдах ажилтнуудын нэр хаяг утас

в/ төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт

г/ байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж

2. Сум, хэрэгжүүлэгч агентлагийн ажлыг иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнгээр үнэлж дүгнэж, тусгай самбарт ил тод байрлуулж сурталчилдаг болсон

3. Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн эрхлэх асуудлын хүрээнд эрх зүйн сургалт, сурталчилгааны төв байгуулж тэнд төрийн үйлчилгээ авахтай холбоотой материал, хууль тогтоомжийн талаархи чухал шаардлагатай бүх мэдээллийг байрлуулан иргэдэд үнэ төлбөргүй үйлчилж байна. 2009 онд энэ төв 1100 иргэнд үйлчилсэн байна.

4. 2009 онд аймгийн Засаг дарга нийтээр дагаж мөрдүүлэхээр шийдвэр гаргаагүй бөгөөд 2005 оноос хойш аймгийн Засаг даргын гаргасан шийдвэрийг нэгбүрчлэн судалж, эмхэлж цэгцэлж байна. 2009 онд аймгийн ЗДТГазрын Хууль зүйн хэлтэс сумдын Засаг дарга нарын гаргасан 1096 захирамжийг хянан үзэж, хуулинд нийцээгүй, иргэдийн эрхийг зөрчсөн 4 захирамжийг хүчингүй болгох асуудлыг аймгийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлсэн байна.

5. 2009 онд аймгийн хөгжлийн хөтөлбөр, 2010 онд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичиг боловсруулахдаа төр, захиргааны удирдах ажилтнууд, эрдэмтэн мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж ажиллуулсан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд Төрийн бус байгууллагын төлөөлөл оруулсны дээр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дэргэд ахмадын болон залуучууд, эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулан тэдний саналыг шийдвэрийн төсөлд тусгадаг болсон.

6. Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Даваа гарагт иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг журам тогтоосон. Энэ үеэр Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагийн дарга нарыг байлцуулан иргэдийн санал хүсэлтэд газар дээр нь хариу өгүүлдэг болсон. Аймгийн

ЭМ газар, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газарт иргэдийн гомдол мэдээллийг хүлээн авах утсыг тогтмол ажиллуулдаг болсон.

7.2009 онд аймгийн хэмжээгээр 6310 иргэний санал, гомдол, өргөдөл хүлээн авч 5679 буюу 90 хувьд нь хуулийн хугацаанд хариу өгч 631 буюу 10 хувийг нь холбогдох байгууллагуудад шилжүүлсэн байна.

8.Аймгийн ЗДТГазар нутгийн захиргааны байгууллагын удирдлагын ил тод, нээлттэй шуурхай, шударга, хариуцлагатай, ажил хэрэгч байдлыг хангахад тухайн байгууллагын үйл ажиллагааны журам, дүрэм, чиг үүргийг иргэд олон нийтэд сурталчлж ойлгуулах явдал чухал гэж үзэж төрийн үйлчилгээний байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг уламжлалттай боллоо. 2009 онд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёлын газрын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, иргэдэд дээрх байгууллагуудын үйл ажиллагааг танилцууллаа.

Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

1.УИХ-аас 2004 онд батлан гаргасан “Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын Хүний нөөцийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллаж байна.

2.Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах зорилгоор эхний ээлжинд Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт албан хаагчдын тухай мэдээллийг цахим сүлжээнд байршуулаад байна

3.Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийн тухай мэдээллийг жилийн эцсээр нэгтгэн гаргаж байгууллагын албан хаагчдын зөвлөгөөнөөр хэлэлцэн санал хүсэлтийг нь авдаг журамтай боллоо.

4.Улирал бүр нутгийн захиргааны байгууллагуудын аппаратын ажилтны зөвлөлгөөн хийж, байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг авч ажилдаа тусгаж байна.

5.2009 онд аймгийн хэмжээнд төрийн албанд гарсан 74 сул орон тоог нийтэд зарлаж, тэдгээрт 580 гаруй хүн өрсөлдөн төрийн албаны шалгалтанд орж, 128 хүн төрийн албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдэж тэдгээрээс 50 иргэн ажилд ороод байна.

6.2009 онд аймаг, сумдын ЗДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэх журам боловсруулан мөрдөж эхэллээ.

Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал

1. Жил бүрийн эхний улиралд ирэх оны төсвийн төслийг боловсруулахад анхаарах асуудал, байгууллагын эрхэм зорилго, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд төсвийн төслийг чиглүүлэх талаар нийт төсөвт байгууллагад мэдээлэл өгдөг болсон. Төсвийн төслийг аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнө нийт төлөөлөгчид, төсвийн байгууллагын эрх баригчид, ТББ-ын удирдлагуудад 5-10 хоногийн өмнө танилцуулж саналыг нь авч байна.

2. 2009 оны төсөв, 2008 оны төсвийн гүйцэтгэлийн талаар аймгийн радиогоор 4 удаа мэдээлсний дээр аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн цахим хуудсанд байрлуулж, иргэд байгууллагууд мэдээллийг чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн.

3. 2009 онд төрийн үйлчилгээний 5 байгууллагын нээлттэй хаалганы өдөр зохиож, тэдгээр байгууллагын төсөв, түүний зарцуулалтыг зүйл анги бүрээр нь иргэдэд тайлбарлан танилцуулсан

4. Төсөвт байгууллага бүрийн тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэлийг мэдээллийн самбарт ил тод байрлуулдаг болсон

5. 2009 онд аймгийн 2008 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг бүрэн эхээр нь аймгийн радиогоор 4 удаа мэдээлж, улс төрийн нам, төрийн бус байгууллагуудад албан ёсоор танилцуулсан байна

6. Үйлчилгээний хөлс болон төлбөр хураамжийн талаарх мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт ойлгомжтой хэлбэрээр тавьж сурталчилсан байна.

7. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төсвийн хууль, журам зөрчсөн 2 хүнийг ажлаас халж 6 ажилтанд сахилгын шийтгэл ноогдуулж энэ тухай нийтэд мэдээлсэн болно

Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

1. 2009 оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсөл, арга хэмжээ нэг бүрээр баталж нийтэд мэдээлсний дээр байгууллагын дотор мөрдөх журмыг боловсруулан баталж мөрдөж ажилласан байна

2. 2009 онд 100,0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 5 ажлыг Сангийн яамны цахим сүлжээнд байршуулж, тогтмол шинэчилж байсан. Нээлттэй тендерийн урилга, холбогдох баримт бичиг, шалгаруулалт явуулах журмыг төвийн өдөр тутмын сониноор, харин харьцуулалтын аргаар шалгаруулах тендерийг орон нутгийн хэвлэл, радиогоор зарлаж, ил тод байдлыг хангаж ажилласан байна.

3. Үнэлгээний хороонд хуулинд заасны дагуу мэргэжсэн ажилтнуудыг ажиллуулж байгаагийн дээр төрийн бус байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулсан байна

4. 2009 онд тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийг сонгон шалгаруулсан үндэслэлийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр ил тод мэдээлсэн ба энэ талаар ямар нэгэн зөрчил, санал гомдол гараагүй байна

5. Нийт тендерт оролцогчдод шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар компаний төлөөлөл, иргэдэд тухай бүр танилцуулж байсан

6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг 1 дүгээр сарын 15-ны дотор гаргаж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.

7. Худалдан авах ажиллагааны чиглэлээр 2009 онд 3 хүнийг мэргэшүүлсэн байна.

8. 2009 онд худалдан авах ажиллагаатай холбоотой 111 өргөдөл хүлээн авч тухай бүр хариу өгсөн байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

